

Mongolian language for foreigners – Week 4
Lecture №4

Сэдэв: Монгол хэл аялгуу
Topic: Mongolian language and dialect

Сонсох, ярих, унших, бичих чадварыг дээшлүүлэх
listening, speaking, reading, writing

Mongolian National University Arts And Culture
Professor, Basbish.S

Хичээлийн агуулга - Lecture content

1. Өмнөх хичээлийн бататгал- Reviewing pervious learning
2. Монгол хэл аялгуу – Mongolian language and dialect
3. Дасгал ажлууд- Exercises
4. Шинэ үг хэллэгүүд- New words
5. Гэрийн даалгавар - Homework

Өмнөх хичээлийн бататгал буюу гэрийн даалгавар
Reviewing pervious learning and homework

Мэдлэг шалгах тест - Test

1. Монгол улсын төрийн далбаанд ямар ямар өнгө орсон байдаг вэ?

- А. Улаан, хөх, шар б. Улаан, ногоон, хөх в. цагаан, хөх, ногоон г. улаан, цагаан, ягаан

2. Монгол улсын төрийн далбааны улаан өнгө ямар бэлгэдэлтэй вэ?

- А. Нар б. Мандан бадрах в. Мөнх тэнгэр г. Амгалан тайван байх

3. Монгол улсын төрийн далбааны хөх өнгө ямар бэлгэдэлтэй вэ?

- А. Нар б. Мандан бадрах в. Мөнх тэнгэр г. Амгалан тайван байх

4. Төрийн соёмбыг хэн зохиосон бэ?

- А. Чингис хаан б. Жавзандамба хутагт в. Занабазар г. Д.Сүхбаатар

5. Соёмбо гэдэг нь “өөрөө гарсан гэгээн” гэсэн утгатайүг.

- А. Монгол б. Санскрит в. Төвөд г. Энэтхэг

Өмнөх хичээлийн бататгал буюу гэрийн даалгавар
Reviewing pervious learning and homework

Мэдлэг шалгах тест - Test

6. Монгол төрийн сүлд ньбэлгэдсэн цагаан өнгийн бадамлянхуа цэцгэн суурьтай.

- А. Цэвэр ариуныг б. Амар амгаланг в. Гоо үзэсгэлэнг г. Сайхан сэтгэлийг

7. Монгол төрийн сүлд ньбэлгэдсэн дугариг хөх дэвсгэртэй.

- А. Гол мөрнийг б. Мөнх тэнгэрийг в. Эх дэлхийг г. цэцгийг

8. Монгол төрийн сүлдийг мөнхөд үргэлжлэн дэлгэрэхийн бэлгэдэл.....хээгээр хүрээлсэн байдаг.

- А. Хаан сүйх б. Хатан сүйх в. Түмэн насан г. Үүлэн


9. Монгол төрийн сүлдэн дээр тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бэлгэдэн алтан.....дүрсэлсэн байдаг

- А. гардийг б. Нарыг в. загасыг г. соёмбыг

10. Монгол төрийн сүлдэн дээр бэлгэдэн, эрдэнийн хүлгийг дүрсэлсэн байдаг.

- А. Энх тайвныг б. Арга ухааныг в. Цог хийморийг г. Хурд хүчийг

МОНГОЛ ХЭЛ АЯЛГУУ ЛЕКЦ-4
Mongolian language and dialect lecture -4



Цэрэнсодном, Д. (2016, February 18). Нэг үг боловч нэмэр болох юуны магад [Photograph]. <https://gogo.mn/r/179437?i=>

Дасгал 1. Асуултыг уншаарай. - Read the questions.

1. Монгол хэл хэлний аль язгуурт багтдаг вэ?
2. Монгол хэлнээс салбарлан хөгжсөн ямар ямар хэл байдаг вэ?
3. Монгол хэлэнд хичнээн төрлийн аман аялгуу байдаг вэ?
4. Монгол хэлний голлох аялгуу аль нь вэ?

Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.
Exercise 2. Listen and fill the missing words

Нөхөх үгс - Choose from following words : Алтай язгуурын, нутгийн аялгуу, хүн ам, аман аялгуу, монгол туургатан, суурьшсан, бие даасан, монгол бичгийн, тодорхойгүй, суурь

Монгол хэл нь манж-түнгүүс, түрэг (зарим эрдэмтэд япон, солонгос хэлийг оруулдаг) хэлтэй нэг гаралтай. Өөрөөр хэлбэл эдгээр хэл эрт цагт нэгэн өвөг хэлнээс салбарлан хөгжсөн гэж үздэг бөгөөд тэр хэлийг нь 1) Алтай язгуурын хэл гэж нэрлэдэг. Алтай хэлтнүүд Алтай нуруу орчмоос Хянганы уулс, Байгаль нуур орчмоос Их цагаан хэрэм хүртэлх өргөн уудам нутагт байсан гэж олонх судлаачид үздэг.

МОНГОЛ ХЭЛ АЯЛГУУ ЛЕКЦ-4
Mongolian language and dialect lecture -4

Нөхөх үгс - Choose from following words : Алтай язгуурын, нутгийн аялгуу, хүн ам, аман аялгуу, монгол туургатан, суурьшсан, бие даасан, монгол бичгийн, тодорхойгүй, суурь

Монгол хэл Алтай хэлнээс салбарлан, бие даан хөгжсөн боловч хэдийд Алтай хэлнээс салбарлан гарав гэдэг нь тодорхойгүй байна. МЭӨ II зуунд Хүннү гүрний үед түрэг, монгол, манж-түнгүс хэлнүүд салж, 2) _____ хэл болсон байсан гэдэг.

Дундад зууны үед Монгол хэлнээс дагуур, монгор, баоань, дунсянь зэрэг хэл тасран гарч, халимаг, буриад хэлнүүд бие даан хөгжих хандлагатай болсон байна.

МОНГОЛ ХЭЛ АЯЛГУУ ЛЕКЦ-4
Mongolian language and dialect lecture -4

Нөхөх үгс - Choose from following words : Алтай язгуурын, нутгийн аялгуу, хүн ам, аман аялгуу, монгол туургатан, суурьшсан, бие даасан, монгол бичгийн, тодорхойгүй, суурь


Одоо бие даасан монгол хэлнүүд хаана Монгол байдаг, хир олон хүн ярилцдаг талаар товч өгүүлье.

Баоань хэл: Энэ хэлээр ярилцагчид БНХАУ-ын Гансу муж, Цинхай мужид оршин суудаг. Нийт 3) _____ нь 1990 онд 12,000 гаруй байв.

Дунсянь хэл: БНХАУ-ын Гансу мужид оршин суудаг. Нийт хүн ам нь 1990 онд 374,000 орчим байв.

МОНГОЛ ХЭЛ АЯЛГУУ ЛЕКЦ-4

Mongolian language and dialect lecture -4



Монгол хэлтнүүд [Mongolian languages]. (2014, March 18). Wikipedia. Retrieved April 19, 2023, from https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB_%D1%85%D1%8D%D0%BB#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:MongolianLanguages.jpg

МОНГОЛ ХЭЛ АЯЛГУУ ЛЕКЦ-4
Mongolian language and dialect lecture -4

Нөхөх үгс - Choose from following words : Алтай язгуурын, нутгийн аялгуу, хүн ам, аман аялгуу, монгол туургатан, суурьшсан, бие даасан, монгол бичгийн, тодорхойгүй, суурь

Могол хэл: Афганистаны Херат, Бадакшан, Маймана зэрэг мужуудад оршин суудаг бөгөөд хүн амын тоо нь 4) _____ байна.

Монгор хэл: БНХАУ-ын Гансу, Цинхай мужид оршин суудаг бөгөөд нийт хүн ам нь 1990 онд 191,000 гаруй байв.

МОНГОЛ ХЭЛ АЯЛГУУ ЛЕКЦ-4

Mongolian language and dialect lecture -4



Монгол хэл [Mongolic]. (2014, April 7). Wikipedia. Retrieved April 19, 2023, from https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB_%D1%85%D1%8D%D0%BB#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Mongolic.jpg

Нөхөх үгс - Choose from following words : Алтай язгуурын, нутгийн аялгуу, хүн ам, аман аялгуу, монгол туургатан, суурьшсан, бие даасан, монгол бичгийн, тодорхойгүй, суурь

Дагуур хэл: БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймаг, Хар мөрөн мужийн Хайлар, Чичигар хотын Ноны голын хөндий, Шинжаны Кулжа зэрэг газар оршин суудаг. Хүн ам нь 1990 онд 121,000 гаруй байв.

Халимаг хэл: XVII зууны эхээр баруун Монголоос өрнө зүг нүүж, Ижил мөрний орчимд 5) _____. Тэдний ихэнх нь ОХУ-ын Халимагийн автономит улсад суудаг. 1990 онд Халимаг улсад 174,000 халимаг хэлээр ярьдаг хүн байв. Бусад газар байдаг Халимагуудын тоо тодорхойгүй байна.

Нөхөх үгс - Choose from following words : Алтай язгуурын, нутгийн аялгуу, хүн ам, аман аялгуу, монгол туургатан, суурьшсан, бие даасан, монгол бичгийн, тодорхойгүй, суурь

Буриад хэл: Ихэнх буриад хэлээр ярилцагчид ОХУ-ын БАУ-д амьдардаг. 1989 онд 490,000 буриадаар ярьдаг хүн байв. Буриадууд нь ОХУ-ын Эрхүү, Чита муж мөн БНКазахстан Улс, БНКиргиз Улс, Узбек, Монгол, БНХАУ-д амьдардаг.

Монгол хэл: Төв монгол хэлээр ярилцагчдын ихэнх нь Монгол улсад амьдардаг. Нийт 3,300,000 орчим хүн бий. Өвөрмонгол 5 сая хүн амтай. Ордос, Үзэмчин, Түмэд, Хорчин, Баарин гэх мэт олон аялгатай.

Нөхөх үгс - Choose from following words : Алтай язгуурын, нутгийн аялгуу, хүн ам, аман аялгуу, монгол туургатан, суурьшсан, бие даасан, монгол бичгийн, тодорхойгүй, суурь

Монгол улсад байгаа 6) _____ нь өөр хоорондоо ихээхэн ялгаатай халх, буриад, ойрд гэсэн 3 том бүлгээс бүрдэх бөгөөд эдгээр аялга нь олон жижиг 7) _____ болон задарна.

Халх аялга: Хамгийн олон хүн ярьдаг. Орчин цагийн монгол утга зохиолын хэлний 8) _____ болдог. Халх аялгыг

- Төв халхын аман аялга
- Баруун халхын аман аялга
- Зүүн халхын аман аялга гэж хуваана.

МОНГОЛ ХЭЛ АЯЛГУУ ЛЕКЦ-4
Mongolian language and dialect lecture -4

Нөхөх үгс - Choose from following words : Алтай язгуурын, нутгийн аялгуу, хүн ам, аман аялгуу, монгол туургатан, суурьшсан, бие даасан, монгол бичгийн, тодорхойгүй, суурь

Ойрд аялга: Уг аялгаар ярилцагчдын ихэнх нь Ховд, Увс зэрэг баруун аймгуудад суудаг. Ойрд аялга нь дундад зууны үеийн монгол хэлтэй зарим талаар адил ба 9) _____ хэлэнд ойрхон харин буриад, халх аялгаас авиан зүй, хэл зүй, үгсийн сангийн хувьд нилээд ялгаатай. Ойрд аялгыг:

- Дөрвөд аман аялга
- Захчин аман аялга
- Баяд аман аялга
- Торгууд аман аялга гэж хуваана.

МОНГОЛ ХЭЛ АЯЛГУУ ЛЕКЦ-4
Mongolian language and dialect lecture -4


Нөхөх үгс - Choose from following words : Алтай язгуурын, нутгийн аялгуу, хүн ам, аман аялгуу, монгол туургатан, суурьшсан, бие даасан, монгол бичгийн, тодорхойгүй, суурь

Буриад аялгуу: Монгол хэлний буриад аялгуугаар Дорнод, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий аймгийн зарим суманд суудаг буриадууд ярьдаг.

Дэлхий дээр найман сая гаруй 10)_____ амьдарч байгаа бөгөөд 3,3 сая гаруй нь Монгол улсад, үлдсэн хэсэг нь ОХУ, БНХАУ болон бусад оронд амьдарч байна. БНХАУ-д байгаа Өвөр Монголчуудын 87% нь хятад хэлээр, ОХУ-д байгаа халимаг, тувачуудын 86% нь орос хэлээр ярьж байна.

МОНГОЛ ХЭЛ АЯЛГУУ ЛЕКЦ-4

Mongolian language and dialect lecture -4



MAP 1. Map of the modern Mongolic languages

Монгол хэл [Mongolic Lang-map]. (2014, April 26). Wikipedia. Retrieved April 19, 2023, from https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB_%D1%85%D1%8D%D0%BB#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Mongolic_Lang-map.jpg

Дасгал 3. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.

Exercise 3. Discuss about following questions and review your understanding

1. Алтай язгуурын хэлэнд ямар ямар хэл багтдаг вэ?
2. Эдгээр хэлтнүүдийг яагаад Алтай язгуурын хэлтнүүд гэж нэрлэсэн бэ?
3. Монгол хэл хэзээ бие даасан хэл болон хөгжсөн бэ?
4. Монгол язгуурын ямар ямар хэл БНХАУ-д байна вэ?

Дасгал 3. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.

Exercise 3. Discuss about following questions and review your understanding

5. Монгол язгуурын ямар ямар хэл ОХУ-д байна вэ?
6. Монгол язгуурын хэлээр ярьдаг үндэстэн өөр ямар улсад байна вэ?
7. Халх аман аялгууг юу юу гэж ангилдаг вэ?
8. Ойрад аман аялгууг юу юу гэж ангилдаг вэ?

МОНГОЛ ХЭЛ АЯЛГУУ ЛЕКЦ-4
Mongolian language and dialect lecture -4

***Дасгал 4. Тохирох байранд том үсгийг хэрэглэнэ үү.
Exercise 4 Put capital letters in appropriate place.***

1. халимагууд нь 1607 оноос ойрадаас тасран ижил мөрний сав газар луу нүүсэн.

.....

2. БНХАУ-ЫН ШИНЖААНД ТОРГУУД, ХОШУУД, УРИАНХАЙ, ӨӨЛД УГСААСТНУУД АМЬДАРДАГ.

.....

3. монгол улсын ойрад, буриад, казахаас бусад хэлнүүдийг төв монгол хэл аялгуу гэнэ.

.....

4. ховд, увс, баян-өлгий аймагт суух баруун монголчууд ойрадын аман аялгуутай.

.....

МОНГОЛ ХЭЛ АЯЛГУУ ЛЕКЦ-4
Mongolian language and dialect lecture -4

***Дасгал 4. Тохирох байранд том үсгийг хэрэглэнэ үү.
Exercise 4 Put capital letters in appropriate place.***

1. төв ба өмнөд аялгууны завсрын аман аялгуу нь альшаа, эзнээ голын болон ховдын ойрад аялгуу юм.

.....

2. ОХУ-ЫН АСТРАХАНЬ, РОСТОВ, ДОН, ВОЛГАГРАД МУЖИД ХАЛИМАГ ХЭЛТНҮҮД БАЙДАГ.

.....

3. монгол улсын дорнод, сэлэнгэ, хөвсгөл, хэнтий аймгууд буриад аман аялгуутай.

.....

4. сэнгээ, цумагари зэрэг эрдэмтэд дагуур хэлний үгсийн 50 хувь нь монгол гэж үзжээ.

.....

МОНГОЛ ХЭЛ АЯЛГУУ ЛЕКЦ-4
Mongolian language and dialect lecture -4

Дасгал 5: А. Өгөгдсөн үгсийг тайлбартай нь тохируулна уу.
Exercise 5: A. Match following words to its explanation

- | | |
|----------------|---|
| 1. Эх хэл | а) харь улсын хэл |
| 2. Гадаад хэл | б) төрөлх хэл, өөрийн үндэсний хэл |
| 3. Бичгийн хэл | в) хэлгүй хүн бодол санаагаар гар хэл, биеийн хөдөлгөөнөөр илэрхийлэх харилцааны тусгай хэрэглүүр |
| 4. Ярианы хэл | г) тухайн хэлнийхээ хэл зүй болон үгсийн сан, дуудлагын хувьд хэм хэмжээ болдог, бүх нийтээрээ хэрэглэдэг боловсорсон хэл |
| 5. Дохионы хэл | д) өгүүлэгч этгээдийн хэлэх хэмнэл, өнгө аяс, хүчлэл зэрэг харилцан адилгүй байдал |
| 6. Аман аялгуу | е) бичиг зохиолын хэлний нэгэн төрөл зүйл, өдөр тутмын ахуй амьдралын яриа |
| 7. Аялга | ё) оршин суугаа газар нутаг, хэв заншил, гарал үүсэл зэргээрээ нэгдмэл хүмүүсийн хэлэлцдэг өвөрмөц онцлогтой хэл яриа |

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 37)

МОНГОЛ ХЭЛ АЯЛГУУ ЛЕКЦ-4
Mongolian language and dialect lecture -4

Дасгал 5: Б. Дээрх үгсийг ашиглан өгүүлбэрийг гүйцээж бичнэ үү.

Exercise 5: B. Complete the sentence using above words

Эх хэл, гадаад хэл, бичгийн хэл, ярианы хэл, дохионы хэл, аман аялгуу, аялга

1. 1999 онд ЮНЕСКО жил бүрийн 2 дугаар сарын 21-ний өдрийг “Олон улсын**Эх хэл**.....-ны/ний өдөр” хэмээн зарлажээ.
2. Гадаад хүмүүс монголоор ярихдаа бага зэрэг –тай ярьдаг.
3.сурснаар дэлхий ертөнцийг таньж мэдэх нэгэн шинэ хаалга нээгдэнэ.
4. –ыг/ийг хар яриа болон боловсон яриа гэж ангилдаг.
5. –ны/ний хамгийн гол суурь нь хэл зүйн мэдлэг болдог.
6. –ны/ний үг гэдэг нь үндэсний бичиг зохиолын хэлний хэм хэмжээнд үл хамаарах, тодорхой нэг ястан буюу нутаг дэвсгэрийн хүрээнд аман ярианд хэрэглэгдэх үгс юм.
7. 2019 оны байдлаар Монголд 9,000-15,000 орчим сонсголгүй хүн байдаг ба тэдгээрийн 80 орчим хувь нь –аар⁴ харилцдаг гэсэн тооцоо бий.

МОНГОЛ ХЭЛ АЯЛГУУ ЛЕКЦ-4

Mongolian language and dialect lecture -4

***Шинэ үг хэллэгүүдийг цээжилж, утгыг ойлгоорой.
Memorize the new vocabularies and understand the meaning***

1. ...-аас⁴ ... хүртэл(х) - ... from ... to ...
2. Адил - same
3. Автономит улс – autonomous country
4. Алтай язгуурын хэл – Altaic language
5. Аялга - accent
6. Аялгуу - dialect
7. Бие даасан - independent
8. Бүлэг – group
9. Гаруй – over, more, than
10. Голын хөндий – river valley
11. Дундад зууны үед – in the Middle Ages
12. Дурсгал - remain
13. Монгол туургатан – the Mongolia
14. Муж – province
15. Нэг гарал – same origin
16. Олонх – most of
17. Орчим – around, about
18. Орчин цагийн - modern

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 38)

МОНГОЛ ХЭЛ АЯЛГУУ ЛЕКЦ-4

Mongolian language and dialect lecture -4

***Шинэ үг хэллэгүүдийг цээжилж, утгыг ойлгоорой.
Memorize the new vocabularies and understand the meaning***

19. Өвөг хэл – ancestral /parental/ language
20. Өөрөөр хэлбэл – in other words
21. Өөр хоорондоо – between each other
22. Өргөн уудам – wide
23. Хандлагатай болох – to tend
24. Салах – to be separated
25. Салбарлах – to branch
26. Судлаач – researcher, scientist
27. Суурь - fundament
28. Тасран гарах – to be separated
29. Товч өгүүлэх – to tell in brief
30. Тодорхойгүй - unclear
31. Утга зохиол - literature
32. Хөгжих – to develop
33. Эрт цагт – in ancient times
34. Ялгаатай - different
35. ярилцагчид - speakers

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 38)

МОНГОЛ ХЭЛ АЯЛГУУ ЛЕКЦ-4
Mongolian language and dialect lecture -4

Гэрийн даалгавар 1
Homework 1



<https://thenounproject.com/icon/homework-3841940/>

- *Сэдэвт гарсан шинэ үг хэллэгүүдийг цээжлээрэй.*
Memorize vocabulary in the given topic
- *Өөрийн орны хэл аялгууны талаар бичээрэй.*
Write about the dialect of your country

МОНГОЛ ХЭЛ АЯЛГУУ ЛЕКЦ-4
Mongolian language and dialect lecture -4

Гэрийн даалгавар 1
Homework 1
Мэдлэг шалгах тест - Test

1. Алтай хэлтнүүдорчмоос Хянганы уулс, Байгаль нуур орчмоос Их цагаан хэрэм хүртэлх өргөн уудам нутагт байсан гэж олонх судлаачид үздэг.
- А. Алтай нуруу Б. Хэнтийн нуруу В. Хангайн нуруу Г. Гималайн нуруу
2. МЭӨ II зуунд үед түрэг, монгол, манж-түнгүс хэлнүүд салж, бие даасан хэл болсон байсан гэдэг.
- А. Сяньби улсын Б. Жужан улсын В. Хүннү гүрний Г. Их монгол улсын
3.хэлээр ярилцагчид БНХАУ-ын Гансу муж, Цинхай мужид оршин суудаг.
- А. Буриад Б. Могол В. Халимаг Г. Баонь
4.хэлээр ярилцагчид БНХАУ-ын Гансу мужид оршин суудаг.
- А. Дунсянь Б. Могол В. Монгор Г. Дагуур
5. Хэлээр ярилцагчид Афганистаны Херат, Бадакшан, Маймана зэрэг мужуудад оршин суудаг.
- А. Дунсянь Б. Могол В. Монгор Г. Дагуур

МОНГОЛ ХЭЛ АЯЛГУУ ЛЕКЦ-4
Mongolian language and dialect lecture -4

Гэрийн даалгавар 1
Homework 1

Мэдлэг шалгах тест - Test

6. хэлээр ярилцагчид БНХАУ-ын Гансу, Цинхай мужид оршин суудаг.

А. Дунсянь Б. Могол В. Монгор Г. Дагуур

7. хэлээр ярилцагчид БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймаг, хар мөрөн мужийн Хайлар, Чичигар хотын Нони голын хөндий, Шинжааны Кулжа зэрэг газар оршин суудаг.

А. Дунсянь Б. Могол В. Монгор Г. Дагуур

8. хэлээр ярилцагчдын ихэнх нь ОХУ-ын Халимагийн автономит улсад суудаг.

А. Буриад Б. Могол В. халимаг Г. баонь


9. Төв Хэлээр ярилцагчдын ихэнх нь Монгол улсад амьдардаг.

А. Монгол Б. Могол В. монгор Г. дагуур

10. Монгол улсад аялгуугаар

А. халх Б.буриад В. халимаг Г.ойрд

(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 40)



Монгол овог, ястан үндэстэн [Photograph]. (2019, February 18).

www.mongolcom.mn. <http://www.mongolcom.mn/entertainment/id/16289>

Ном зүй

Мөнхцэцэг, Г., Орхон,Б. (2021). Монгол орон судлал. Улаанбаатар: Линограф ХХК.

Цэрэнсодном, Д. (2016, February 18). Нэг үг боловч нэмэр болох юуны магад [Photograph].

<https://gogo.mn/r/179437?i=>

Монгол хэлтнүүд [Mongolian languages]. (2014, March 18). Wikipedia. Retrieved April 19, 2023, from

[https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB_%D1%85%D1%8D%D0%BB#/media/](https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB_%D1%85%D1%8D%D0%BB#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:MongolianLanguages.jpg)

[/media/ %D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:MongolianLanguages.jpg](https://mn.wikipedia.org/wiki/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:MongolianLanguages.jpg)

Монгол хэл [Mongolic]. (2014, April 7). Wikipedia. Retrieved April 19, 2023, from

[https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB_%D1%85%D1%8D%D0%BB#/media/](https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB_%D1%85%D1%8D%D0%BB#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Mongolic.jpg)

[/media/ %D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Mongolic.jpg](https://mn.wikipedia.org/wiki/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Mongolic.jpg)

НОМ ЗҮЙ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ-REFERENCES

Mongolian language [Mongol atlas]. (2014, March 18). Wikipedia. Retrieved April 19, 2023, from

https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB_%D1%85%D1%8D%D0%BB#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Mongol_atlas.jpg

Монгол хэл [Mongolic Lang-map]. (2014, April 26). Wikipedia. Retrieved April 19, 2023, from

https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB_%D1%85%D1%8D%D0%BB#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Mongolic_Lang-map.jpg

Монгол овог аймаг ястан [Mongolia]. (2008, June 6). Wikipedia. Retrieved April 19, 2023, from

https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D0%BE%D0%BD%D0%B3%D0%BE%D0%BB_%D1%85%D1%8D%D0%BB#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Atlas_Mongolica.jpg

Монгол овог, ястан үндэстэн [Photograph]. (2019, February 18). www.mongolcom.mn.


<http://www.mongolcom.mn/entertainment/id/16289>

Анхаарал хандуулсанд баярлалаа

Дараагийн хичээл хүртэл
баяртай!



https://www.flaticon.com/free-icon/teacher_1995413



<https://thenounproject.com/icon/lecture-1525984/>